



**ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/24

Жаргалант сум

“Эрүүл Жаргалантчууд” хөтөлбөр болон  
хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгүүдийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эрүүл Жаргалантчууд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Засаг дарга (Л.Учрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.БИЛГҮҮНБААТАР



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны  
09/24 тогтоолын нэгдүгээр хавсралт

## “ЭРҮҮЛ ЖАРГАЛАНТЧУУД” ХӨТӨЛБӨР

### Нэг.Ерөнхий мэдээлэл

Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө, Орхон аймгийн ЭМС-ын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө, Орхон аймагт хэрэгжиж буй “Эмч” дэд хөтөлбөрийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд, Монгол улсын “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөж байгаа “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэхийн тулд нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдэд түлхүү анхаарах, жендерийн тэгш байдлыг хангах, үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн тэдний эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй байдлаас үл хамааран хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд үйл ажиллагааны зүй зохистой уялдаа холбоог сайжруулахад оршино.

Жаргалант сумын нийт хүн ам 2024 оны байдлаар 3293 хүрч, нийт хүн амын 52 хувийг эрэгтэйчүүд, 48 хувийг эмэгтэйчүүд эзэлж, насны бүтцийн хувьд нийт хүн амын 25.9 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 33.8 хувийг 15-39 насны, 33 хувийг 40-64 насны, 7.3 хувийг 65-аас дээш насныхан эзэлж байна. Сүүлийн жилүүдэд төрөлт буурч байгаа үзүүлэлттэй байна.

Хүн амын дунд амьсгал, хоол боловсруулах, зүрх судасны тогтолцооны өвчлөл, хавдар, осол гэмтэл, гадны шалтгаант өвчлөл нэмэгдэж, сүүлийн 5 жилийн байдлаар нас баралтын тэргүүлэх өвчлөлийг зүрх судасны тогтолцооны өвчин (42,4%), хавдар (34.8%), осол, гэмтэл, гадны шалтгаан (7,5%) эзэлж байгаа нь эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр нас барсан 2,5 хүн тутмын нэг нь зүрх судасны тогтолцооны өвчнөөр, мөн 3 хүн тутмын нэг нь хорт хавдрын улмаас, 8 хүн тутмын нэг нь гэмтэл, хордлого, гадны шалтгааны улмаас нас баржээ.

Орхон аймгийн хэмжээнд хийгдсэн халдварт бус өвчний суурь судалгаагаар хүн амын 36 хувь нь хөдөлгөөний хомсдолтой, 17,6 хувь нь таргалалттай, 27 хувь нь тамхи хэрэглэдэг, 63,3 хувь нь согтууруулах ундаа хэрэглэдэг, 71,4 хувь нь жимс, хүнсний ногоог 5 нэгжээс доош хэрэглэдэг гэсэн дүгнэлт гарсан нь эрсдэлт хүчин зүйлийн тархалт өндөр байгааг харуулж байгаа бөгөөд 25-45 насны ид ажиллаж, хөдөлмөрлөх насны идэвхтэй хүн амд, ялангуяа эрэгтэйчүүдэд зонхилж байгаа нь манай суманд ч тулгамдсан асуудал болоод байна.

Сүүлийн 10 жилд халдварт өвчний хөдлөл зүй нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд хүн амын дунд тохиолдож буй халдварт өвчний дийлэнхи хувийг амьсгалын замын халдварт өвчин эзэлж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Орхон аймагт нийт халдварт өвчний 36,5%-ийг амьсгалын замын халдвар эзэлж байгаагийн 49,2 хувийг салхинцэцэг, 38 хувийг сүрьеэ эзэлж байна. Нийт халдварт өвчний 35.4 хувийг мөөгөнцөр, 19,2 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 8,2 хувийг гэдэсний халдвар тус тус эзэлж байна. Сүүлийн жилүүдэд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдвар, салхинцэцэг, гар хөл амны өвчин, хачигт халдвар, гэдэсний халдвар нэлээдгүй бүртгэгдсэн.

Тус сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд шүд цоорох өвчин 70 гаруй хувьтай байгаа ба сүүлийн 2 жил хөтөлбөрийн хүрээнд “Хаш” шүдний эмнэлэгтэй хамтран ажиллаж,

шүдний цоорлыг зогсоох, эрүүл шүдийг цоорлоос хамгаалах хамгаалалтын фторт түрхлэгийг түрхсэн нь зохих хувь нэмрээ оруулсан. Цаашид шүд, амны хөндийн эмчилгээг зайлшгүй хийх, эцэг эхчүүдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орчны бохирдол жилээс жилд нэмэгдэж, Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын цөөрмийн "Цагаан тоос", Хангалын голын усны бохирдол, хогийн цэг, түлшний үйлдвэрийн шаталтын утаа зэрэгт салхины чиглэлийн дагуу сумын иргэд ус, хөрс, агаарын бохирдлын бүсэд амьдарч байна. Цагаан тоосны нөлөөллийг бууруулах хөтөлбөрийн хүрээнд суурьшлын бүсэд амьдарч байгаа иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажилд манай сумын 702 иргэн хамрагдсан боловч эцсийн дүгнэлт хараахан гараагүй байна.

Улаантолгой багийн өрхийн 40 гаруй хувь нь гар аргаар гаргасан худагнаас хүнсний ногоогоо услахын зэрэгцээ хүнс, ахуйн хэрэгцээндээ хөрсний ус хэрэглэж байгаа нь эрүүл ахуйд нийцэхгүй байна.

Дээрх нөхцөл байдал, судалгаануудын дүнгээс үзэхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хэрэгцээ их байгаа боловч авч чадахгүй, авсан ч цаг хугацаанд нь чанартай авч чадахгүй байгаа, нас баралтын шалтгаан болсон зүрх судасны өвчлөл, хорт хавдрыг эрт шатанд нь эмнэлэгт хандаж, оношилж, эмчлүүлээгүй нь тодорхой байна. Иймд сумын хэмжээнд иргэдийн ялангуяа зорилтот бүлгийн хүн амд хүрч үйлчлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх чадавхи болон эрүүл мэндийн тогтолцоог орон нутгийн түвшинд бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байгааг харуулж байна. Монгол улсын Засгийн газар, ЭМЯ, аймаг орон нутгаас эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд арга зүйн болон санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж, эрүүл мэндийн байгууллагууд чамлахааргүй үр дүнд хүрч байгаа хэдий ч нийгэм, эдийн засаг, орчны хүчин зүйлсээс хамаарсан эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд хэвээр байна. Иймд бид сумын хүн ам, өрхийн амьжиргааны түвшин, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, өвчлөлийн чиг хандлагад нийцүүлэн орон нутагт оношлогоо, эмчилгээний шинэ дэвшилтэт арга барилыг нэвтрүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, хүн амд эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх ялангуяа эмзэг бүлгийн болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүртэж чадахгүй байгаа бүлгийн иргэдэд үйлчлэх, эрүүл мэндийн салбарт оруулах орон нутгийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тусгасан хөтөлбөр зайлшгүй шаардлагатай байна.

## **Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зарчим, хэрэгжүүлэх чиглэл**

### **2.1.Зорилго**

Сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэлээ болгон эмчилгээ, оношлогооны шинэ арга барилыг нэвтрүүлэх, эмийн бус эмчилгээг өргөжүүлэх, эрүүл мэндийн үйл ажиллагаанд санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх замаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.


### **2.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

2.2.1.Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл,оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл, соёл, амьдралын түвшний ялгаа зэргээс үл хамааран "Хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчимд тулгуурлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх;

2.2.2.Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;

2.2.3.Хөтөлбөрийн хэрэгжилт нээлттэй ил тод байх

2.2.4.Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх



### **2.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл:**

2.3.1.Нийгмийн эрүүл мэнд

2.3.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2.3.3.Хүний нөөц

2.3.4.Эрүүл мэндийн технологи

### **Гурав.Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн**

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

#### **3.1.Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:**

Орон нутгийн төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын идэвх санаачлага, дэмжлэг тусалцаа, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдийн оролцоотойгоор нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.1.1.Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан насанд тохирсон өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах, иммунологийн аппарат болон шаардлагатай оношлуураар хангах

3.1.2.Гэр бүл, төлөвлөх, эмэгтэйчүүд, эсэн мэнд амаржих, эх хүүхдийн эндэгдлээс сэргийлэх, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

3.1.3.Хүүхдийг эхийн сүүгээр хооллох нөхцлийг бүрдүүлэх, 0-5 насны хүүхдийн суурь өвчлөлийг эрт илрүүлэх, шаардлагатай хүүхдүүдийг зуны чийрэгжүүлэлтэнд хамруулах ажлыг зохион байгуулах

3.1.4.Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах

3.1.5.Сумын хүн амын хүнсний хангамж, хэрэглээнд хяналт, үнэлгээ, судалгаа хийх, эрүүл хооллолтыг дэмжих замаар хүн амын дундах жингийн илүүдэл, амин дэм, эрдэс бодисын дутлыг бууруулах (0-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд)

3.1.6.Эрүүл мэндийг дэмжих орчинг бүрдүүлэх, эрүүл аюулгүй ажлын байрыг дэмжих зорилгоор эрүүл мэндийг дэмжигч хамт олон, эрүүл өрх, эрүүл иргэнийг шалгаруулж урамшуулах

3.1.7.Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй халдварт бус өвчний нийтлэг эрсдэлт хүчин зүйл болох архи, тамхины хэрэглээ, зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдлын тархалтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоог дэмжсэн нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах

3.1.8. Сумын хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх, иргэдийн эрүүл мэндийн талаарх хүчин чармайлтыг дэмжих, урамшуулах

3.1.9. Урьдчилан сэргийлэх үзлэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, 2 болон 3 дахь шатлалын эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах

3.1.10. Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулах, эмчлэн эрүүлжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах

3.1.11. Хөдөөгийн алсмагдмал багийн иргэдэд явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, мобайл технологийг ашиглах, эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах

#### **Хүрэх үр дүн:**

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сайжирч, эрүүл мэндийг дэмжсэн нийгмийн дэмжлэгт орчин бүрдэнэ. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирна.

#### **3.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр:**

Эмнэлгийн тусламж үйлчилгээг сумын хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан, ил тод, хариуцлагатай, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн анхан шатны тусламжийг хөгжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.2.1. Сумын эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлэх

3.2.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ “үйлчлүүлэгч төвтэй” байж, хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах,

3.2.3. Үйлчлүүлэгчид үзүүлэх дараагийн шатлалын хэрэгцээг зөв тодорхойлж, эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулах

3.2.4. Түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгах, алслагдсан болон газар зүйн хувьд бэрхшээлтэй нутагт оршин суугаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх

3.2.5. Тусламж үйлчилгээнд уламжлалт анагаах ухааны оношилгоо эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хэрэглэх, хөгжүүлэх

3.2.6. Сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

3.2.7. Сумын хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээнд түлхүү анхаарч, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

#### **Хүрэх үр дүн:**

Үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, уламжлалт анагаах ухааны оношлогоо, эмчилгээг нэвтрүүлсэн байна.

### **3.3 Хүний нөөцийн чиглэлээр:**

Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлага харилцааг сайжруулах, нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана.



#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.3.1.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн болон, ажлын байрны, богино хугацааны болон зайн сургалтанд хамруулах

3.3.2.Нийт ажиллагсадыг “Эмч” дэд хөтөлбөр, төрийн албан хаагчийн хөтөлбөрт хамруулах

3.3.3.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байран дээр сургах сургалтын танхимтай болох, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын багаж хэрэгслээр хангах

3.3.4.Анагаахын шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад болон дотооддоо суралцуулах, туршлага судлуулах, сэлгэн ажиллуулах

3.3.5.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг мэргэжлийн уламжлал, хувь хүний хандлагад тулгуурлан ажиллаж байгаа бүх хугацаанд төлөвшүүлэх, эрүүл мэндийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах

3.3.6.Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, эрүүл мэндийн ажилтныг ажлын байрны эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах

3.3.7.Шинэ залуу боловсон хүчин, эмч, мэргэжилтнүүдийг орон байраар хангаж, сум орон нутгаас дэмжлэг үзүүлэх

3.3.8.Эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, онцгой нөхцөлд хүний амь насыг аварсан болон төрийн дээд одон, медалиар шагнагдсан эмч, ажилтнуудад мөнгөн урамшуулал олгох

#### **Хүрэх үр дүн:**

Эмнэлгийн мэргэжилтний боловсон хүчний хангалт тогтвортой, мэргэжлийн ур чадвар сайжирч, ажиллагсдын урам зориг нэмэгдсэн байна.

### **3.4 Эрүүл мэндийн технологи, тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр:**

Эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа барилга байгууламж, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүчин чадал, ашиглалт, хангалтын байдалд үнэлгээ, төлөвлөлт хийж, анхан шатны тусламжийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.4.1.Интернетийн хурдыг нэмэгдүүлж, “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх

3.4.2.Эмч, мэргэжилтнүүдийг компьютер, принтер бусад тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах

3.4.3.Эмийн бус эмчилгээний өрөөг тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

3.4.5.Эмийн бус эмчилгээний болон сувилахуйн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай байгаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах

3.4.6. Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдлээр ханган хүүхдийн үзлэгийн тусгайлан бэлтгэсэн өрөө тасалгааг тохижуулах

3.4.7. Эмнэлгийн гадна орчны тохижилт, автомашины зогсоол, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбай байгуулах, гадна фасад хийж эмнэлгийн орчныг тохижуулах

3.4.8. Хуучин автомашины гражыг засварлах зураг төсөв хийлгэх, засвар хийх

#### **Хүрэх үр дүн:**

ЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагааны стандарт хангагдаж, шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамж нэмэгдэн, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

#### **Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа**

2025-2028 онуудад жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

#### **Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

1. Орон нутгийн төсөв
2. Орон нутгийн хөгжлийн сан
3. Эрүүл мэндийн төвийн төсөв
4. Хандив тусламж
5. Бусад зардал

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны  
09/11 тогтоолын хоёрдугаар хавсралт

“ЭРҮҮЛ ЖАРГАЛАНТЧУУД” ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.12.22

Жаргалант


№	Хэрэгжүүлэх хэмжээ	арга	Хэрэгжүүлэх хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Шардлагатай төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
<b>Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:</b>										
Орон нутгийн төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын идэвх санаачилга, дэмжлэг тусалцаа, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдийн оролцоотойгоор нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуртээмж чанарыг сайжруулах										
1.1	Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан насанд тохирсон өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах	Жилийн турш	ЭМДС	ОНТ ЭМДС ЭМТ-ийн төсөв	-Хамрагдсан иргэдийн тоо -Илрүүлсэн өвчлөл -Эмчлэгдсэн байдал	Насанд тохирсон эрт илрүүлэг үзлэгийн хувь 40,3 хувь байна.	Насанд тохирсон өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувийг улс, аймгийн түвшнээс бууруулахгүй, зохих үр дүнд хүрсэн байна.	ЭМТ	ЭМГ ЭМДТ	
1.2	Хөгжлийн бэрхшээлтэй, эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо эмчилгээнд хамруулах	2,4-р улиралд	ОНТ	Нэгдсэн журмаар аймгаас санхүүжүүлдэг	-Хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо -Илрүүлсэн өвчлөл -Эмчлэгдсэн байдал	Бүртгэлтэй эмэгтэйчүүдийн 80 орчим хувь хамрагддаг.	Бүртгэлтэй эмэгтэйчүүдийг 95 хувиас доошгүй хамруулж, оношилгоо эмчилгээнд хамрагдсан байна.	ЭМТ	ЭМГ	
1.3	Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж,	2, 4-р улиралд	ОНХС	5.0 сая	- Хамрагдсан хүүхдийн тоо -Илрүүлсэн өвчлөл	Сургууль болон цэцэрлэгийн хүүхдийг 100 хувь урьдчилан сэргийлэх үзлэгт	Давтан үзлэг, хамгаалалтын турхлэг хийх, шаардлагатай хүүхдүүдийн	ЭМТ	ХХЭМБ ЗДТГ, ЕБС, 3-р цэцэрлэг	

	эмчлэн эрүүлжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах			-Эмчлэгдсэн байдал	оруулсан, хамгаалалтын болон фторт түрхлэг хийгдсэн, бүх хүүхэд шүдний карттай болсон.	байнгын 30 шүдний эмчилгээг хийсэн байна.	<div style="border: 2px solid red; padding: 5px; width: fit-content; margin-bottom: 5px;">         Accredited of Gov.          Method of       </div>
1.4	Урьдчилан сэргийлэх үзлэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, 2 болон 3 дахь шатлалын тарелжсэн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах	Жилийн турш	ОНТ	-Урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо -Хамрагдсан иргэдийн тоо -Илрүүлсэн өвчлөл	ЭМД-гүй иргэд тарелжсэн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт орох боломжгүй байгаа.	Иргэдэд ЭМД төлөлтөөс үл шалтгаалж үзлэгт хамрагдах боломжийг гаргаж, өвчнийг эрт нь хугацаанд эмчлэн илрүүлэх, эрүүлжүүлэх, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг ойроос хүртэх боломж бүрдсэн байна.	ЭМТ ЗДТГ

**Зорилт 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр:**

	Сумын эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлэх, лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх, аппарат, тоног төхөөрөмж, бусад дагалдах оношлуур, хэрэгслээр үе шаттай хангах	Жилийн турш	ОНТ	-Өргөжүүлсэн ТҮ-ний тоо, төрөл -Нэмэгдсэн аппарат, тоног төхөөрөмжийн нэр, тоо төрөл, ашиглалт	Лабораторид ЦЕШ, биохими, ШЕШ, туузан оношлуураар шинжилгээ хийгдэж байгаа. Иммунологийн аппарат байхгүй. Мөн ЭМД-ын санхүүжилтийн хүрэлцээгүй байдлаас (7 сараас хойш гүйцэтгэлийн санхүүжилт ирээгүй) оношлуур, аппаратын уусмал авч чадахгүй байгаа	Нэмэлтээр иммунологийн аппарат, холестрин хэмжигчээр хангагдаж, цусан дахь өөх тосны солилцоо, витамин Д, сахрын 3 сарын дундаж, төмөр, үе мөчний үрэвсэл, зүрхний дутагдал илрүүлэх, бамбайн даавар, эр эм бэлгийн дааврыг тоон үзүүлэлтээр үзэх боломжтой болно.	ЭМТ ЭМГ ЗДТГ
2.1			19,5 сая				

Эмнэлгийн тусламж үйлчилгээг сумын хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан, ил тод, хариуцлагатай, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн анхан шатны тусламжийг хөгжүүлнэ.

2.2	Сэргээн хөнгөвчлөх, сувилахуйн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмийн бус эмчилгээний болон гэрийн сувилахуйн тоног төхөөрөмжөөр хангах	Жилийн турш	ОНТ	16 сая	-Тусламж, үйлчилгээний төрөл, тоо, тайлан Нэмэгдсэн аппарат, тоног төхөөрөмжийн нэр, тоо төрөл, ашиглалт	Сумын ЭМТ-ийн стандартад заагдсан сэргэн засах эмчилгээний тоног төхөөрөмж дутагдалтай	Поток, хэт авиан эмчилгээний аппарат, истра-1 аппарат, өвдөгний үений, нүдний толгой, хэвлийн хэсэгчилсэн эмчилгээнд ашиглах аппарат, тоног төхөөрөмжөөр хангагдаж, сэргэн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна.	 ЭМГ ЗДТГ
-----	---	-------------	-----	--------	--	--	--	--

**Зорилт 3. Хүний нөөцийн чиглэлээр:** Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлаг харилцааг сайжруулах, нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана.

3.1	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн төрөлжсөн мэргэжлийн болон, ажлын байрны, богино хугацааны болон зайн сургалтад хамруулах, мэргэжлийн чиглэлээр туршлага судлах, сэлгэн ажиллуулахад дэмжлэг үзүүлэх	Жилийн турш	-	-	-Сургалтын тоо -Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо -Багц цагийн биелэлт	Сургалтын агуулга, чиглэлийн хувьд хязгаарлагдмал хамрагддаг.	Хамрагдалтыг нэмэгдүүлж, багц цаг бүрэн биелж, эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар нэмэгдсэн байна.	ЭМТ ЭМХТ ЭМГ
3.2	Нийт ажиллагсдыг "Эмч" дэд хөтөлбөр, төрийн албан хаагчийг дэмжих хөтөлбөрт хамруулах	Жилийн турш	ОНТ	-	-Хамрагдсан ажилчдын тоо -Тэтгэмжийн хэмжээ	Эмч хөтөлбөрт хамрагдсан ажилчдын тоо харьцангуй цөөн байгаа	Нийгмийн дэмжлэгт хамрагдсан ажиллагсдын хувь нэмэгдсэн байна.	ЭМТ ЭМГ ЗДТГ

**Зорилт 4. Эрүүл мэндийн технологийг сайжруулах** Эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа барилга байгууламж, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүчин чадал, ашиглалт, хангалтын байдалд үнэлгээ, төлөвлөлт хийж, анхан шатны тусламжийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

4.1	Эмнэлгийн барилгын гадна фасад, дээвэр, гэрэлтүүлэг агааржуулалтын хоолой, бохирын шугамны засвар хийх зураг төсөв гаргаж, хийж гүйцэтгэх	2,3-р улиралд	ОНТ	төсөв	-Засвар хийгдсэн байна.	Гадна гэрэлтүүлэггүй, агааржуулалт муу, бохирын шугам хоолойн үнэр байнга үнэртдэг	Засвар хийгдэж, эмнэлгийн ажиллагааны стандарт хангагдана.	ЭМТ ЗДТГ
4.2	Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдлээр ханган хүүхдийн үзлэгийн тусгайлан бэлтгэсэн өрөө тасалгааг тохижуулах	2-3 дугаар улиралд	ОНТ	18 сая	Хангалт, ажлын тайлан	Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдэл, дутагдалтай, орчин үеийн шаардлага хангасан үзлэгийн өрөөгүй	Хүүхдийн нас тохирсон иж бүрдлээр хангагдана 1 өрөөг тохижуулна.	ЭМТ ЗДТГ
	<b>Нийт төсөв</b>			<b>61,5 сая</b>				

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

ЭМТ-ИЙН ДАРГА

Ц.ДЭЛГЭРМАА